



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2017 оны 11 сарын 14 өдөр

Дугаар А/440

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд тусгагдсан төсөл, арга хэмжээний хүрээнд батлагдсан Эрүүл мэндийн сайдын 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн "Жагсаалт батлах тухай" А/418 дугаар тушаалын 4. Харъяа эрүүл мэндийн байгууллагуудын их засвар жагсаалт /2017 оны тодотгол/-ын 12. Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн агааржуулалтын системийн засвар 79,000,000 /далан есөн сая/ төгрөгийн төсвийг зарцуулах эрх /гэрээ байгуулах, сунгах, цуцлах, хяналт тавих, санхүүжүүлэх/-ийг Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн дарга /Н.Цогбадрах/-д шилжүүлсүгэй.

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулан, ажлын гүйцэтгэлийг тайлагнаж ажиллахыг Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн дарга /Н.Цогбадрах/-д даалгасугай.

3. Эрх шилжүүлсэнтэй холбогдуулан ажлын гүйцэтгэл, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

081427